



БИД КОКСЖИХ НҮҮРСНИЙ ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ БӨГӨӨД ДООРХ НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНДАА ТАНЫГ УРЬЖ БАЙНА

ГЕОЛОГИЧ

Гүйцэтгэх үндсэн үүрэг:

Үйл ажиллагаа эрхэлсэн захирлын удирдлага дор, геологийн гэрээтүүдийг удирдаж, нөөцийг олборлолтонд бэлтгэнэ. Ордын геологийн загварчлалыг гардан хийх ба геологи, геофизикийн датабаазын менежмент зэрэг геологитой холбоотой бүх ажил, үүргийг хариуцана:

- Хамаарал бүхий бүх компаниудын геологийн болон нүүрсний чанартай холбоотой мэдээлэл болон холбогдох бүх data /нүүрсний чанар, өрмийн цооног, лиценз гэх мэт/-ны хадгалах, зохион байгуулах, хөгжүүлэлт, шинэчлэлтийг хариуцах;
- Хамаарал бүхий бүх компаниудын эзэмшдэг компьютерийн геологи загварыг зохион байгуулах, хадгалах, хийж бэлтгэх болон холбогдох засварлалтыг хийж гүйцэтгэх;
- Техникийн судалгаанд дэмжлэг үзүүлэх. Жишээлбэл: нөөц, нөөцийн тооцоо, техник эдийн засгийн үндэслэл эсвэл бусад техникийн шинж чанартай бизнесийг хөгжүүлэх ажилд холбогдох тооцоо, судалгааг хийх, туслах;
- Одоо байгаа орд болон ирээдүйд хайгууль хийгдэх ордын талаарх геологийн болон холбогдох ойлголтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай хайгуулийн ажлын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, түүнийг удирдах, өртөг, гэрээ, загварчлалыг хийж гүйцэтгэх;
- Компанийн эзэмшдэг геологийн өгөгдлийг бусад ажилчдад үнэн зөв, тогтвортой, хүртээмжтэй, хадгалахад хялбар болгох үүднээс геологийн процесстой холбоотой дотоод журмын төслийг боловсруулах;
- Ажлын байрны тодорхойлолтод заагдсан бусад ажил үүргийг гүйцэтгэх

Ажлын байранд тавигдах шаардлага:

- Геологич инженер болон ижил төстэй мэргэжлээр баклавраас доошгүй зэрэгтэй байх;
- Бичгийн болон ярианы ахисан төвшний англи хэлний мэдлэгтэй;
- Ахисан түвшинд геологийн загварчлалын програмуудыг ашигладаг байх;
- 5-аас доошгүй жилийн нүүрсний хайгуулын туршлагатай;
- Геологийн загварчлалын 3 жилийн туршлагатай;

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ:

- CV
- Боловсрол, мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар

БИЧИГ БАРИМТ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА:

Бүрдүүлэх бичиг баримтыг hr@khurgataikhairkhan.mn хаягаар 2021 оны 05-р сарын 31-ний өдрийн 17:00 цаг хүртэл хүлээн авна. Лавлах утас: 7011-6828

Жич: Зөвхөн анхан шатны сонгон шалгаруулалтад тэнцсэн ажил горилогчтой эргэн холбогдох болно.